

ТӨРӨӨС БИЕЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн нийтэд хотжилт, техник, технологийн хөгжил хурдацтай хөгжин суурин иргэншил давамгайлах болж, хүн амын амьдралын хэв маяг өөрчлөгдөн улс орнууд биеийн тамир, спортыг дэмжих замаар хүний дундаж наслалтыг дээшлүүлэх, хүнийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Монгол Улсын хүн амын 67 хувь нь хот, суурин газарт амьдарч байгаа бөгөөд хүн амын 64 хувийг 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж байна. Бие бялдрын сорилын 2017 оны судалгаагаар өсвөр үеийнхний 80.2 хувь нь бие бялдрын хөгжлийн хувьд "С" буюу тухайн насныхаа бие бялдрын хөгжлийн түвшингээс доогуур, илүүдэл жин ба таргалалтын түвшингээр Ази тивдээ хамгийн өндөр, хүн амын 55 хувь буюу 2 хүний нэг нь илүүдэл жин, таргалалттай байгаа нь хөдөлгөөний хомсдолтой холбоотой өвчлөл, эндэгдэл нэмэгдэхэд хүргэж байна.

Олон улсын спортын тавцанд Монголын тамирчдын үзүүлж байгаа амжилт нь тусгаар тогтнолоо бататгах, улс орны хөгжлийн түвшинг илэрхийлэх, эх оронч үзлийг сурталчлахад онцгой ач холбогдолтой билээ. Түүнчлэн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, спорт нь бүх нийтэд хүртээмжтэй, тогтвортой байснаар хувь хүний хөгжлийг дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх хамгийн үр дүнтэй, аюулгүй, нийгэм-эдийн засгийн үр ашигтай аргын нэг юм.

Иймээс хүн амд үзүүлэх биеийн тамирын үйл ажиллагаа, идэвхтэй хөдөлгөөн, спортыг орон нутгийн нөхцөл байдал, хувь хүний онцлог, бие бялдрын хөгжилд нийцсэн олон хувилбартай, сонголт хийх боломжоор ханган хөгжүүлж, оюуны болон бие бялдрын өв тэгш хөгжилтэй, хөдөлмөрийн бүтээмж сайтай иргэдтэй байж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэхийг хувь хүний хэрэглээ болгох, хамт олон, байгууллагын түвшинд хэвшүүлэх шаардлагатай байна.

Эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад биеийн тамир, спортын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хөгжих нөөц боломжийг эрхэмлэн үзэж, хүний хөгжлийг хангах гол хүчин зүйл болохыг нь онцлон "Төрөөс биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (цаашид "бодлого" гэх)-ыг тодорхойлов.

Энэхүү бодлогын цөм нь биеийн тамирын үйл ажиллагаа байх бөгөөд идэвхтэй хөдөлгөөн, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон орон даяар өрнүүлэх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, хүн амын ажил, амьдралын салшгүй хэрэглээ болгох, улмаар Монгол хүний дундаж наслалтыг уртасгахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Энэхүү бодлого нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг юм.

Хоёр. Бодлогын зорилго, баримтлах зарчим

Биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, спорт, хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгох, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэхэд бодлогын зорилго оршино.

2.1. Биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, спорт хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

2.1.1. Биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын гол чиглэл нь биеийн тамирын үйл ажиллагаа байх;

2.1.2. Биеийн тамирын үйл ажиллагааны хүрээнд идэвхтэй хөдөлгөөн, спортын бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэний нэгдмэл үйл ажиллагаа, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг ханган хэрэгжүүлэх;

2.1.3. Иргэдэд бие бялдрын боловсрол олгох үйл явц нь шинжлэх ухааны үндэслэлтэй, тасралтгүй, хүртээмжтэй, чанартай, залгамж шинжтэй байх;

2.1.4. Биеийн тамирын үйл ажиллагаа, идэвхтэй хөдөлгөөн, спортын үйлчилгээг иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурлан, чанартай, хүртээмжтэй байлгах, санхүүжилтийг архи, тамхи болон хууль бус бусад асуудлаас ангид байлгах.

2.1.5. Биеийн тамирын үйл ажиллагаа, идэвхтэй хөдөлгөөн, спортын үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн санхүүжилтийг газар зүйн байршил, хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх үе шат, зорилт

3.1. Бодлогыг 2017-2028 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2018-2022 он;

Хоёрдугаар үе шат: 2023-2028 он;

3.2. Идэвхтэй хөдөлгөөн, спортыг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны хэрэглээ болгон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажиллах чадварыг дээшлүүлэх хэрэглүүр болгох бодлогын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.2.1. биеийн тамирын хичээлийн хөтөлбөр, агуулгыг хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжил, боловсрол, соёлыг дээшлүүлэхэд чиглүүлэх, тэднийг секц, дугуйланд тогтмол, тасралтгүй хамрагдан хичээллэх үндсэн нөхцөлийг хангаж, спортын заал, талбайгүй сургуулиудыг стандартын заал, талбайтай болгох, спортын хэрэглэл, материалын хангамж, орчны хүртээмжийг нэмэгдүүлэх, шинээр баригдах ерөнхий боловсролын сургуулийн заал, талбайн стандартыг тогтоож хэрэгжүүлэх;

3.2.2. Биеийн тамирын үйл ажиллагааг бүх нийтийн хөдөлгөөн болгох, хүн амын бүлэг, нас, ажил, амьдралын онцлог, ажиллах чадварт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлэх, иргэдийг амралт, чөлөөт цагаараа ажлын байр болон амьдрах орчиндоо идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчныг бүрдүүлэхийг дэмжих;

3.2.3. Олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцсэн заал, талбай, дэд бүтцийг улс, бүс, аймгийн хэмжээнд спортын тодорхой төрлөөр төрөлжүүлэн барьж байгуулах, иргэдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн ажил, үйлчилгээ эрхлэх талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс гарсан санал, санаачилгыг дэмжих,

3.2.4. Хүн ам, ялангуяа хөдөлгөөний хомсдолтой иргэд, ахмад настны дунд биеийн тамирын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх явдлыг дэлгэрүүлэх, техник хэрэгсэл, тоноглолын хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх;

3.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах.

3.2.6. Биеийн тамирын үйл ажиллагаа, идэвхтэй хөдөлгөөн, спортын үйлчилгээний чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн салбарын түвшинд ажлын байр бий болгон, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бүртгэл, мэдээллийг сайжруулах;

3.3. Тамирчдын ур чадварыг үндэсний шигшээ багийн бүх түвшинд ахиулах, сургалт-дасгалжуулалт, тэмцээн, спортын наадмын шаталсан тогтолцоогоор зохион байгуулж, спортыг хөгжүүлэх, тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чадвартай болгох бодлогын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.3.1. Улсын хэмжээнд жигд хөгжин олимп, тив, дэлхийн түвшинд хүрсэн спортын төрлүүдийг төрөөс дэмжихийн зэрэгцээ хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлэх, олноор нь хамруулж, эх оронч үзэл, хүмүүжлийг олгох, улс орныхоо төлөө зүтгэх эрмэлзлийг төрүүлэх зорилгоор багийн спортын төрлүүдээр хичээллэх, тэмцээн зохиох, хамрагдан оролцохыг дэмжих;

3.3.2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэхийн тулд спортын холбоо, клубыг чадавхжуулах, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжиж төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлж, санхүүжилтийг олгох, шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх шаталсан тогтолцоог боловсронгуй болгох, холбоодын болон үндэсний шигшээ багийн тамирчдын сургалт-дасгалжуулалтад дэмжлэг үзүүлэх;

3.3.3. Спортын цол, зэрэг, тамирчид, дасгалжуулагчдын урамшууллыг тэдний хариуцлага, ёс зүйтэй холбох талаар холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.3.4. Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцон медаль хүртэж, эх орныхоо нэрийг олон улсын тавцанд гаргасан тамирчин, дасгалжуулагчид олгох урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх;

3.3.5. биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, спортын чиглэлээр ажиллаж байгаа ажилтан, арга зүйч, багш, дасгалжуулагчдыг гадаад, дотоодод бэлтгэх, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх сургалтын тогтолцоог

бүрдүүлэх, төрийн болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлэх.

3.4. Спортын шинжлэх ухаан, спортын анагаах ухааны судалгаа, шинжилгээ, туршилт, нотолгоонд суурьлсан биеийн тамир, спортын ажил, үйлчилгээг хөгжүүлэх бодлогын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.4.1. Биеийн тамир, спортын чиглэлээр мэргэжилтэн /баклавр/ бэлтгэж буй их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг олон улсын түвшинд хүргэх, төгсөгчдийн чанарыг дээшлүүлэх

3.4.2. Биеийн тамир, спортын мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, мэргэжил дээшлүүлэх дэд тогтолцоог бий болгох,

3.4.3. Спортын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтыг эрдэмтэн судлаач, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаар хэрэгжүүлэх, төрийн захиалгаар гүйцэтгүүлэх судалаа, шинжилгээ, туршилтын ажлын чиглэлийг тодорхойлох механизм бүрдүүлж, мэргэжилтэн бэлтгэх болон төгсөлтийн дараах сургалтын уялдуулах;

3.4.4. Биеийн тамирын арга зүйч, дасгалжуулагчдийн үйл ажиллагаанд мөрдөх стандарт, жишиг хөтөлбөрийг боловсруулах ажлыг үргэлжилүүлж, эдгээрт суурьлсан хяналтын дэд тогтолцоог бүрдүүлэх;

3.4.5. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийг байгуулах

3.4.6. Спорт дахь допингийн эсрэг үйл ажиллагааны үндэсний чадавхийг сайжруулах, допингийн эсрэг үндэсний дүрмийг хэрэгжүүлэх.

3.5. Биеийн тамир, спортын салбарт төрийн ба төрийн бус байгууллагын зохистой түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох бодлогын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.5.1. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн бүх шатны байгууллага нь спортын холбоод, биеийн тамир, спортын бусад байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, биеийн тамир, спортын төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

3.5.2. Гадаад улсын буцалтгүй тусламж, олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглүүлж, төсвийн бус санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

3.5.3. Спортод тулгуурласан стратегийн түншлэлийг бий болгон гадаад, дотоодын бизнесийн байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх, биеийн тамир, спортыг дэмжигч аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх замаар биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;

3.5.4. Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн цахим сангийн бүтэц, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх;

3.5.5. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, стратегийн түншлэлийг бий болгох зорилгоор Спортыг дэмжих сангийн хөрөнгийг иргэдийн эрүүл мэндийг

бэхжүүлэх, идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортын ажил, үйлчилгээг эрхэлж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийг дэмжихэд түлхүү зарцуулах;

3.5.6. Эрүүл мэндийн даатгалын санд төлсөн шимтгэлээ ашиглан идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэхэд ашигладаг иргэдийн тоог нэмэгдүүлэх, мөн хүн амын бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй хөдөлгөөн, спортын ажил, үйлчилгээг эрхэлж байгаа спортын клуб, аж ахуйн нэгж, байгууллагыг магадлан итгэмжлэлд хамруулан эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулах зардлыг тодорхой хувиар нэмэгдүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;

---o0o---

Та бүхэн судлан үзэж саналаа доорх хаягаар ирүүлнэ үү.

gerel@mecs.gov.mn

munkherdene@mecs.gov.mn

tungalag@mecs.gov.mn

erdenesuren@mecs.gov.mn